



112

БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/61

Номгон

Сумын Хөдөлмөрийн аюулгүй байдал,
эрүүл ахуйн салбар зөвлөл байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.7, 25.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга

Г.Хүрэлсүх

(Сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд

Э.Балжинням

(Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтний

үүргийг түр орлон гүйцэтгэгч)

О.Дашдаваа

(Боловсрол, соёл, урлагийн асуудал хариуцсан

мэргэжилтэн)

П.Баатар

(Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан

мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч)

О.Цэндмаа

(Эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортын

асуудал хариуцсан мэргэжилтэн)

Б.Баасанжаргал

(Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент,

үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Б.Ууганзаяа

(Худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан

Захирамж 2023 он

621010923

мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга

Г.Сувданцэцэг

(Нийгмийн хамгаалал, хүн ам зүйн асуудал хариуцсан
мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2.Зөвлөлийг удирдлага арга зүйгээр хангаж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр олон талт арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Зөвлөлийн дарга (Г.Хүрэлсүх)-д даалгасугай.

3.Зөвлөлийн үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцож ажиллахыг зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/77 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Г.ЭНХБАЯР